

2016/12/21



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2016 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/88

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/64 дүгээр захирамжаар батлагдсан Тээврийн газрын "Дүрэм"-ийн 2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан аж ахуй нэгж, байгууллагатай гэрээ байгуулах болон нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх, дүнг нэгтгэх, хугацааг сунгах журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журам шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан байгууллагын цахим хуудсанд байршуулахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/-т, холбогдох албан тушаалтнуудад танилцуулахыг хэлтсийн дарга нарт даалгасугай.

3. Тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Тээврийн газрын даргын 2015 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/45 дугаар тушаал, 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/45 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ДОТГОНБААТАР

Нийслэлийн Тээврийн газрын даргын  
2016 оны 12 дугаар сарын 28 ны өдрийн  
88 дугаар тушаалын хавсралт



Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан аж ахуй нэгж, байгууллагатай гэрээ байгуулах болон нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх, дүнг нэгтгэх, хугацааг сунгах журам

### Нэг. Зорилго

1.1. Энэхүү журам нь хотын доторх болон хот орчмын чиглэлд нийтийн зорчигч тээвэр, таксийн үйлчилгээ эрхлэх хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулах, дүгнэх, дүнг нэгтгэх, хугацаа сунгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Монгол Улсын "Автотээврийн тухай" хууль, түүнд нийцүүлэн гаргасан холбогдох стандарт, дүрэм, журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан, хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, таксийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагатай өмчийн хэлбэр харгалзахгүйгээр нийслэлийн Тээврийн газрын Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс нь энэ журмын 3.2-д заасан дүгнэлтийг үндэслэн гэрээ байгуулна.

Хоёр. Гэрээ байгуулах аж ахуйн нэгж,  
байгууллагад тавигдах шаардлага

2.1. Монгол улсын "Иргэний хууль", "Хөдөлмөрийн тухай", "Автотээврийн тухай", "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай" хууль, Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 153 дугаар тушаал, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2011; "Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага" MNS 5012:2011, "Таксийн үйлчилгээ. Ерөнхий шаардлага" MNS 5122:2013, "Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд" MNS 4599:2003 стандартуудын шаардлагыг бүрэн хангасан байх.

2.2 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуй нэгж, байгууллага нь (их багтаамжийн автобусаар үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж нь өөрийн өмчийн тээврийн хэрэгсэлтэй байна) 20-оос доошгүй автобус, троллейбус, 30-аас доошгүй таксийн тээврийн хэрэгсэлтэй байх ба тэдгээр нь техникийн хяналтын улсын үзлэг, тээврийн хэрэгслийн бүртгэлд хамрагдсан, зорчигчдын тав тухтай, осол зөрчилгүй зорчих нөхцөлийг хангаж, холбогдох татвар, хураамжийг бүрэн төлсөн байх.

2.3 Их багтаамжийн автобусаар нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуй нэгж, байгууллага нь "Автотээврийн тухай" хуулийн 10 дугаар

зүйлийн 10.2.8, 10.2.9 дугаар заалтуудыг хангасан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тээвэрлэхэд зориулагдсан нэмэлт тоноглолтой тээврийн хэрэгсэлтэй байна.

2.4. Хотын доторх болон хот орчмын чиглэлд нийтийн зорчигч тээвэр, таксийн үйлчилгээ эрхлэх санал, хүсэлтээ ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь холбогдох хууль, тогтоомж, стандартын нөхцөл шаардлагын дагуу дараах баримт материалыг бүрдүүлж, хуулбарлан хуулийн дагуу баталгаажуулсан байна.

2.4.1 Нийтийн зорчигч тээврийн болон таксийн үйлчилгээг хэвийн явуулах санхүү, эдийн засгийн зохих чадавхитай байх / хүснэгт №1 /

2.4.2 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн өмчид бүртгэлтэй захиргааны байр, дулаан зогсоол, засвар үйлчилгээний байр, тоног төхөөрөмж, суваг өргүүрээр хангагдсан байх ба их багтаамжийн автобусаар үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгжээс бусад аж ахуйн нэгжид түрээсийн гэрээгээр энэ шаардлагыг хангасан байж болно. / хүснэгт №2 /

2.4.3 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуй нэгж, байгууллага нь тээврийн ажил үйлчилгээ, техникийн талаар мэдлэг, дадлага бүхий авто тээврийн мэргэжлийн инженер, механикч, тээвэр зохицуулагчтай, ээлжийн мэргэшсэн жолоочоор хангагдсан байх / хүснэгт №3 /

• 2.4.4 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын автобус, троллейбус, таксийн тээврийн хэрэгсэл нь техникийн хяналтын үзлэгт бүрэн хамрагдсан байх ба тэдгээрийн 80-аас доошгүй хувь нь 8-аас доош жилийн насжилттай байх. / хүснэгт №4 /

2.4.5 Нийтийн зорчигч тээвэр, таксийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын товч танилцуулга / хүснэгт №5 /, байгууллагын удирдах болон инженер, техникийн ажилтангуудын товч анкет, төгссөн сургуулийн диплом, гэрчилгээг хавсралтаар / хүснэгт №6 / тус тус бүрдүүлсэн байна.

2.5 Нийтийн зорчигч тээврийн автобус, троллейбус, таксийн тээврийн хэрэгсэл нь дараах тусгай нөхцөл, шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.5.1 Гарашийн дугаарыг автобусны ар, 2 хажуу талд болон дээвэр (бага багтаамжийн автобусанд хамаарахгүй) дээр өгөгдсөн стандартын дагуу бараан өнгийн дэвсгэр дээр цайвар тод өнгөөр, цайвар өнгийн дэвсгэр дээр бараан тод өнгөөр, байгууллагын эмблемийг 2 хажуу талд болон урд талд, чиглэлийн нэр дугаарыг ар, өвөр, хажуу талд зорчигчдод ил тод харагдахаар байрлуулсан байна.

2.5.2 Таксийн үйлчилгээний тээврийн хэрэгсэл нь жигд өнгийн байх ба байгууллагын эмблем, цоохор тэмдэг, гарашийн дугаарыг 2 хажууд байрлуулж, таксометр, симфорыг заавал тавьж суурилуулсан байна.

2.6 Энэ журмын 3.2-д заагдсан ажлын хэсэг нь нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний төрлөөс хамааран нэмэлт шаардлагыг тавьж болох бөгөөд энэ талаар тус журмын 3.2.4-д заасан журамд тусгасан байна.

2.7 Нийтийн тээврийн үйлчилгээний үндсэн чиглэлд их болон дунд багтаамжийн автобус, троллейбусаар нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх

аж ахуйн нэгж нь энэ журмын 3.2.5-д заасан давуу эрхээр гэрээ байгуулах боломжтой бол энэ журмын 2.2-д заасан тооны 40 хувиас доошгүй тээврийн хэрэгсэлтэй байж болох бөгөөд энэ тохиолдолд тус журмын 2.1-2.4-д заасан шаардлагуудыг бүрэн хангаагүй байж болно.

**2.8** Нийтийн тээврийн үйлчилгээний туслах чиглэл, буухиа үйлчилгээ, таксийн болон такси дуудлагын үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж нь энэ журмын 3.2.5-д заасан давуу эрхээр гэрээ байгуулах боломжтой бол энэ журмын 2.1-2.4-д заасан шаардлагуудыг бүрэн хангаагүй байж болно.

#### Гурав. Гэрээ байгуулах

3.1 Нийтийн зорчигч тээвэр, таксийн үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллага нь гэрээ байгуулах хүсэлтээ энэхүү журмын 2.2-д **2.4.** /1,2,3,4,5,6 дугаар хүснэгт/ дурдсан шаардлагуудыг холбогдох материалын хамт баталгаажуулан нийслэлийн Тээврийн газарт ирүүлнэ.

3.2 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт, түүнд хавсаргасан баримт материалыг үндэслэн тус газраас томилогдсон ажлын хэсэг дүгнэлт гаргаж шийдвэрлэнэ. Тус ажлын хэсэг нь зөвхөн шинээр гэрээ байгуулах хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгжтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх бөгөөд тус газрын даргын тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилогдсон байна.

3.2.1 Энэ журмын 3.2-д заасан ажлын хэсгийн дүгнэлтэд дарга, гишүүд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

3.2.2 Энэ журмын 3.2-д заасан ажлын хэсэг нь гэрээ байгуулах эсэх асуудлаар 30 хоногийн дотор тухайн аж ахуйн нэгжид хариу мэдэгдэх бөгөөд шаардлагатай тохиолдолд газрын даргын зөвшөөрлөөр нэг удаа 30 хоногоор сунгаж болно.

3.2.3 Энэ журмын 3.2-д заасан ажлын хэсгээс гэрээ байгуулах шаардлагыг хангасан тухай дүгнэлт гарсан эсхүл 3.2.5-д заасан давуу эрхээр гэрээ байгуулах шийдвэр гарсан бол энэ журмын 3.2.2-д заасан хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэст хүргүүлнэ.

3.2.4 Энэ журмын 3.2-д заасан ажлын хэсэг нь тусгайлан ажиллах журам боловсруулан мөрдөж болно.

**3.2.5** Нийслэлийн Тээврийн газрын дарга нь дараах зорилгоор нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан аж ахуйн нэгжид гэрээ байгуулах давуу эрх олгож болно.

- Монгол Улсын Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх
- Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих
- Стандартын шаардлага хангасан шинэ /0-3 жилийн насжилттай/ тээврийн хэрэгслээр парк шинэчлэлт хийх

- Их багтаамжийн автобус үйлчлэх боломжгүй чиглэлд дунд болон бага багтаамжийн автобусаар үйлчилгээ үзүүлэх
- Замын нөхцөл сайжирч их багтаамжийн автобусаар үйлчилгээ үзүүлэх шаардлагатай болсон
- Байгалийн шатдаг хий, цахилгаан эх үүсвэрээр ажилладаг автотээврийн хэрэгсэл ашиглах
- Хүн амын нутагшил, байршлын онцлогоос хамааран Нийслэлийн алслагдсан, гэр хорооллын болон шинэ суурьшлийн бүсэд нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх

3.3 Энэхүү журмын дагуу бүрдүүлбэл зохих баримт материалыг дутуу болон хуурамчаар бүрдүүлсэн нь нотлогдвол энэ журмын 3.2-д заасан ажлын хэсэг гэрээ байгуулахаас татгалзах дүгнэлт гаргах бөгөөд гэрээ байгуулснаас хойш энэ байдал тогтоогдвол Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс гэрээг хүчингүй болгоно.

#### Дөрөв. Гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх, дүнг нэгтгэх, маргааныг шийдвэрлэх

4.1 Хэлтэс бүр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд холбогдох үүргийн биелэлтийг сар бүр дүгнэж, гэрээний мэргэжилтэн хэлтсүүдийн дүнг аргачлалын дагуу нэгтгэн аж ахуйн нэгж тус бүрээр нь гаргана.

4.2 Гэрээний үүргийн биелэлтийг хэлтсүүдийн холбогдох мэргэжилтэн дараах байдлаар дүгнэнэ.

4.2.1 Гэрээний үүрэгт заасан "Автотээврийн тухай" хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудын хэрэгжилтийг Автотээврийн хяналтын улсын байцаагчийн торгууль, шийтгэврийн хуудсаар тогтооно.

4.2.2 Энэ журмын 4.2.1-д зааснаас бусад үүргийн биелэлтийг өөрийн хэлтсийн болон холбогдох байгууллагуудаас авсан баримт материалд үндэслэн тоон утгад шилжүүлэн дүгнэж гаргасан байна.

4.2.3 Гэрээнд дурдагдсан тухайн чиглэлийн 1 цагийн дундаж орлогыг тодорхойлохдоо "Улаанбаатар Смарт Карт" ХХК-ийн Удирдлага мэдээллийн болон цахим төлбөрийн системийн гаргасан мэдээллийг үндэслэн тогтооно.

4.2.4 Тухайн цаг үеийн нөхцөл, шаардлагыг харгалзан аж ахуйн нэгжийг урамшуулах болон хариуцлагыг сайжруулах зорилгоор нэмэлт үзүүлэлтүүдээр дүгнэж болох бөгөөд энэ журмын 4.4-д заасан ажлын хэсгийн шийдвэрээр хэрэгжүүлнэ.

4.3 Гэрээний мэргэжилтэн нь хэлтсүүдийн дүгнэсэн материалыг аргачлалын дагуу нэгтгэн хүснэгтээр гаргаж тухайн аж ахуйн нэгжийн холбогдох албан тушаалтанд танилцуулж, энэ журмын 4.4-д заасан ажлын хэсгийн ахлагчаар хянуулсны дараа 1 хувийг аж ахуйн нэгжид өгнө.

4.4 Гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх, дүнг нэгтгэх ажиллагаа болон холбогдох баримт материалтай холбоотой маргаантай асуудлыг шийдвэрлэх үүрэг

бүхий ажлын хэсгийг холбогдох хэлтсийн мэргэжилтнүүдийг оролцуулан 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр газрын даргын тушаалаар байгуулна.

4.5 Энэ журмын 4.4-д заасан ажлын хэсэг нь тусгайлан ажиллах журам боловсруулан мөрдөж болох бөгөөд ажлын хэсгийн шийдвэр нь хурлын тэмдэглэл байна.

4.5.1 Ажлын хэсгийн хуралд гишүүдийн олонх нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болж, оролцсон гишүүдийн олонхийн саналыг харгалзан санал хураах зарчмаар шийдвэр гаргана.

4.5.2 Энэ журмын 4.4-д заасан асуудлуудаас зөвхөн гэрээний торгуультай холбоотой асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар саналаа гаргаж тус газрын захиргааны зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлнэ.

4.6 Гэрээний үүргийн биелэлтийн дүнг нэгтгэх аргачлалыг энэ журмын 4.4-д заасан ажлын хэсэг боловсруулж мөрдүүлнэ. Нэгтгэх аргачлалд хэлтэс бүрийн дүгнэх үзүүлэлт, баримт материалыг тодорхой зааж, гэрээний үүргүүдийг тоон утга бүхий томъёогоор бодогдохоор боловсруулна.

#### Тав. Гэрээний хугацааг сунгах

5.1 Гэрээний хугацааг сунгах эсэх асуудлыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс дараах байдлаар шийдвэрлэнэ. Үүнд:

5.1.1 Эрх бүхий ажлын хэсгийн шийдвэрт болон холбогдох бусад албан тушаалтнуудын дүгнэлтэд тусгайлан гэрээг сунгахаас татгалзсан санал гаргаагүй бол Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс нь тус газрын Захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн хотын доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжийн гэрээг үргэлжлүүлэн сунгана.

5.1.2 Энэ журмын 5.1.1-д заагдсанаас бусад тохиолдолд тухайн гэрээнд заагдсан нөхцөлийн дагуу шийдвэрлэнэ.

5.1.3 Тухайн аж ахуйн нэгж нь өөрчлөн (нэгтгэх, тусгаарлах, өөрчлөх) зохион байгуулагдсанаар анх тавьсан нөхцөл шаардлагыг хангаж байгаа тохиолдолд гэрээг цаашид сунгах бөгөөд энэ шаардлагыг хангаж буй эсэхэд Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэнэ. Нийлүүлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар шинээр бий болсон аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах асуудлыг энэ журмын 3.2-д заасан ажлын хэсэг шийдвэрлэнэ.

#### Зургаа. Бусад

6.1 Энэхүү журмыг зөрчсөн аж ахуйн нэгж, албан тушаалтанд зохих хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2 Энэхүү журамд заагдаагүй харилцаа болон энэхүү журамтай холбоотой үүссэн маргааныг тус газрын Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхээр шийдвэрлүүлнэ.

.....аж ахуйн нэгж, байгууллага,  
иргэний ажил үйлчилгээний хэмжээ,  
санхүү эдийн засгийн чадавхи

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнөх жилийн гүйцэтгэл	Тухайн жилийн төсөл
1	Зорчигчдын тоо	Мян.хүн		
2	Зорчигч эргэлт	Мян хүнкм		
3	Ажил үйлчилгээний орлого	Мян.төг		
4	Ашиг	Мян.төг		
5	Орлогын татвар	Мян.төг		
6	Дундаж тариф	Төг		
7	Бэлэн мөнгө	Мян.төг		
8	Дансны үлдэгдэл	Мян.төг		
9	Дүрмийн сан	Мян.төг		
10	Үндсэн хөрөнгө	Мян.төг		
11	Үүнээс	Тээврийн хэрэгсэл	Мян.төг	
12		Тоног төхөөрөмж	Мян.төг	
13		Байшин барилга	Мян.төг	
14	Эргэлтийн хөрөнгө	Мян.төг		
15	Ажиллагчдын тоо			
16	Үүнээс	Жолооч		
17		Засварчин		
18		Кондуктор		
19		Бусад		

ТЭМДЭГ ЗАХИРАЛ...../...../

.....АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ИРГЭНИЙ  
 ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОЛОН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Д/д	Үзүүлэлт		Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Албан өрөө	өөрийн	м2	
2		Түрээсийн	м2	
3	Засвар, үйлчилгээний байр	Талбай	м2	
4		Суваг	ш	
5		Эстакад	ш	
6		Өргүүр	ш	
7	Дулаан зогсоол	Өөрийн	м2	
8		Түрээсийн	м2	
9	Ил зогсоол		м2	
10	Тээврийн хэрэгслийн тоо		ш	
11	Үүнээс	Ачааны	ш	
12		Автобус	ш	
13		Суудлын	ш	
14		Тусгай зориулалтын	ш	
15	Дундаж даац, багтаамж		тн. хүн	

ТЭМДЭГ ЗАХИРАЛ

/...../



.....АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА,  
ИРГЭНИЙ ТЭЭВРИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧНИЙ ЧАДАВХИ

Д/д	Ажил мэргэжлийн ангилал	Тоо	Ажилласан жил				Мэргэжлийн зэрэг				Боловсрол			
			3 хүртэл	3 - 5	6 - 15	16-	1 - 2	3 - 4	5	6	Дээд	Тусгай	Дунд	
1	Инженер техникийн ажилтан	Удирдлагын менежмент												
		Инженер техникч												
		Механикч												
2	Жолооч /ангилаар/	В												
		С												
		ВС												
		Д												
		ВСД												
		Е												
	ВСДЕ													
3	Мэргэжлийн ажилтан	Авто засварчин												
		Цахилгаанчин												
		Гагнуурчин												
		Моторчин												
		Бусад												
4	Кондуктор													

ТЭМДЭГ

ЗАХИРАЛ

/...../

.....АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ИРГЭНИЙ  
АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

Д/д	Тээврийн хэрэгслийн марк	Улсын дугаар	Үйлдвэрлэсэн он	Техникийн хяналтын үзлэгт орсон огноо, гэрчилгээ №	Байгууллагын дүрмийн санд тусгагдсан эсэх	Жолоочийн овог, нэр	Жолооч болсон он	Ангилал	Мэргэшсэн үнэмлэхийн дугаар
0	1	2	3	4	5	6	7	8	9
1									
2									
3									
4									
5									
6									
7									
8									
9									
10									
11									
12									
13									
14									
15									
16									
17									
18									
19									
20									
21									
22									
23									
24									
25									
26									
27									
28									

ТЭМДЭГ

ЗАХИРАЛ

/...../

.....АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА,  
ИРГЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

1.Аж ахуйн нэгж, байгууллагын байршил, хаяг

.....  
.....

2. Аж ахуйн нэгж,байгууллагын үйл ажиллагааны зориулалт

.....  
Үйлчилгээний чиглэл .....

Хамрах хүрээ.....

3.Аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригч эзний овог,нэр

.....  
төрсөн он сар өдөр.....  
нас,хүйс,ам бүл.....  
боловсрол.....  
мэргэжил .....

4.Аж ахуйн нэгж,байгууллагын эрх баригчийн паспортын дугаар

.....  
Үндсэн захиргаа.....

5.Аж ахуйн нэгж байгууллагын эрх баригч эзний гэрийн хаяг.....

Утас,факсын дугаар.....

**Тайлбар:**Мэргэжлийн дипломын нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргана

ТЭМДЭГ

ЗАХИРАЛ

/...../

**АЖ АХУЙН НЭГЖИЙН УДИРДАХ БОЛОН АВТО ИНЖЕНЕР  
ТЕХНИКИЙН АЖИЛТНЫ ТОВЧ АНКЕТ**

1. Овог ..... Нэр.....  
Эрэгтэй, эмэгтэй /зур/ Төрсөн.....он.....сар

2. Одоогийн захиргаа.....

Хаана ямар ажилтай.....

**ЗУРАГ**

3. Төгссөн сургууль, боловсролын байдал

4.

Хаана ямар сургууль	Орсон он сар	Төгссөн он сар	Эзэмшсэн мэргэжил,диплом гэрчилгээний дугаар

**Тайлбар:**Диплом,гэрчилгээг нотариатаар баталгаажуулсан хуулбарыг хавсаргана.

4. Эрдмийн зэрэг,цол.....

5. Хөдөлмөрийн үйл ажиллагаа

Хаана ямар байгууллагад ямар ажил хийсэн	Ажилд орсон он сар	Ажлаас гарсан он сар	Шалтгаан

6. Одоо ямар албан тушаалд ажиллах.....

ТЭМДЭГ

ЗАХИРАЛ

/...../